



КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА

АГУУЛГА

Бидний суурь бодлого

- Алсын хараа
- Эрхэм зорилго
- Үнэт зүйлс
- ТУЗ-ийн даргын мэндчилгээ
- Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
- Очир Ундраа Группын товч танилцуулга
- Компанийн тухай
- Бидний ололт амжилт
- Нийгмийн хариуцлага
- Бүтээгдэхүүн үйлчилгээ
- Санхүүгийн голлох үзүүлэлтүүд
- Салбарын зах зээлийн тойм
- Харилцагч байгууллагууд
- Хүний нөөц
- Хараат бус аудиторын тайлан

■ БИДНИЙ СУУРЬ БОДЛОГО

АЛСЫН ХАРАА

Хамгийн үр өгөөжтэй санхүүгийн байгууллага болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Мэдрэмж, шинэчлэлийг хослуулж, үнэ цэнэ, бүтээмжээ тасралтгүй нэмэгдүүлэн, тогтвортой байдлыг эрхэмлэж, санхүүгийн цогц бүтээгдэхүүн, үйлчилгээгээр харилцагчдынхаа талархлыг хүлээсэн ёс зүйтэй байгууллага байна.

ҮНЭТ ЗҮЙЛС

- Үнэнч, шударга байдал
- Бүтээлч байдал
- Хариуцлагатай байдал
- Өрсөлдөх чадвартай байдал
- Хүндэтгэлтэй байдал



ТҮҮХЭН ТОВЧООН

2008

- 2008.06.08-ны өдөр Очир Ундраа ОМЗ ББСБ үндэсний 100%-ийн хөрөнгө оруулалттай үүсгэн байгуулагдсан.

2009

- Итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлөө авав.

2010

- Автомашин барьцаалсан зээлийг зах зээлд анх нэвтрүүлэв.

2012

- Баянгол дүүрэгт анхны салбараа нээсэн.

2014

- Зээлийн батлан даалтын сантай хамтран ажиллах гэрээ байгуулагдсан
- Компанийн бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн ТУЗ байгуулагдав.

2016

- Баянзүрх дүүрэгт салбараа нээсэн.
- Онлайн орчинд суурилсан зээлийн хүсэлт илгээх, дансны хуулга харах, гүйлгээ хийх боломжтой цахим үйлчилгээг үйл ажиллагаандаа шинээр нэвтрүүлэв.

2017

- Монгол шошго, Эрдмийн Ундраа, Итгэлийн гар зорилтот зээлийн бүтээгдэхүүнүүдийг зах зээлд шинээр гаргалаа.
- Хөдөө орон нутгийн анхны салбараа Эрдэнэт хотод нээсэн.

2018

- ISO 9001:2015 Олон улсын стандартыг санхүүгийн салбартаа анхлан нэвтрүүлэв.
- Санхүү бүртгэлийн Polaris системийг үйл ажиллагаандаа шинээр нэвтрүүлэв.
- Компанийн 10 жилийн ойн баяр тохиолоо.
- Хан-Уул дүүрэгт салбараа нээсэн.

МЭНДЧИЛГЭЭ



ТУЗ-ИЙН ДАРГА
Д.ЭНХТУУЛ

Эрхэм хүндэт үүсгэн байгуулагч хувьцаа эзэмшигч, үнэ цэнэтэй харилцагч, түншүүд, бүтээлч чадварлаг ажилтан та бүхний энэ өдрийн амар амгаланг тань айлтган мэндчилье!

Бид сайн засаглал, нийгмийн хариуцлагын зарчим, олон улсын стандартуудыг хэрэгжүүлж ажиллахын төлөө байгууллагынхаа нэгдсэн удирдлагын системүүдийг илүү боловсронгуй болгож, шийдвэр гаргалтыг илүү оновчтой байлгах ажлын хүрээнд 2017 оны 03-р сарын 03-ны өдрөөс “Очир Ундраа ОМЗ” ББСБ-ын ТУЗ-ийн багийг шинэчлэн зохион байгуулж, үүсгэн байгуулагчийн болон хамт олны итгэлийг дааж, хариуцлагыг хүлээн миний бие тус ББСБ-ын ТУЗ-ийн даргаар сонгогдон ажиллаж эхэллээ.

Байгуулагдсан цагаасаа эхлэн бүхий л үйл ажиллагаандаа байнгын шинэчлэл, сайжруулалтыг хийж, цэвэр, тунгалаг, шударга, ил тод, ёс зүйтэй байх зарчмыг дээдлэн чанд баримталж ирсэн манай хамт олон цаашид ч мөн энэхүү зарчмаа дээдлэн олон улсад өрсөлдөхүйц хамгийн үр өгөөжтэй санхүүгийн байгууллага байх алсын хараагаа эрхэмлэн тууштай, зүтгэлтэй, бүтээмжтэй ажиллаж харилцагчдынхаа талархлыг хүлээсэн өсөлт хөгжлийн ундраа нь ямагт байх болно.

Тус байгууллагын өнөөдрийг хүртэлх хугацааны ололт амжилт бүрийн цаана бидний итгэлтэй, хариуцлагатай, найдвартай харилцагч бүртэй хийсэн хамтын ажиллагааны үр шим, хамтран ажиллагсад та бүхний хичээл зүтгэл, хөдөлмөр бүтээлийн үр дүн байгаа билээ.

Тиймээс энэхүү амжилтыг хамтдаа бүтээлцэн яваа эрхэм харилцагч, хамтрагч, түншүүд, ажилтнууд та бүхэндээ чин сэтгэлийн талархал илэрхийлэхийн ялдамд, та бидний ажил үйлс улам өргөжин тэлж, өөдлөн бадрахын ерөөлийг өргөө!

МЭНДЧИЛГЭЭ



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.ЦОГТГЭРЭЛ

Эрхэм танд энэ өдрийн амар амгаланг айлтган, чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Бид мэдрэмж, шинэчлэлийг хослуулж, үнэ цэнэ, бүтээмжээ тасралтгүй нэмэгдүүлж, тогтвортой байдлыг эрхэмлэн, санхүүгийн цогц бүтээгдэхүүн үйлчилгээгээр харилцагчдынхаа талархлыг хүлээсэн хариуцлагатай байгууллага болно гэсэн эрхэм зорилго тавьж түүндээ хүрэхээр хичээн ажиллаж, алхам алхмаар өсч дэвжин, амжилтыг санхүүжүүлнэ уриатайгаар харилцагч нартаа тусалж, зөвлөж ирлээ.

Очир Ундраа ОМЗ ББСБ нь байгуулагдсан цагаасаа эхлэн өдгөө 16000 гаруй харилцагчид 170 гаруй тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд энэхүү санхүүжилтээр дамжуулан 3500 гаруй ажлын байр шинээр бий болгоход дэмжлэг үзүүлжээ. Мөн 2018 онд харилцагчиддаа үйлчилгээгээ илүү ойртуулах үүднээс Хан-Уул дүүрэгт шинэ салбараа нээн ажиллуулж, Бичил санхүүгийн хөгжлийн сантай хамтран төслийн зээлийг Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдэд тус тус амжилттай хэрэгжүүлэн дунд болон дундаас доогуур орлоготой зорилтод бүлгүүдэд нийт 1,451.4 сая төгрөгийн бага хүүтэй зээлийг олгосон байна.

Бид эдийн засгийн тогтворгүй нөхцөл байдалд ямагт эрсдэлийг тооцон, хяналттай ажилласны үр дүнд санхүүгийн үзүүлэлт өсөлттэй гарлаа. Тухайлбал компанийн зээлийн багц 25,6 хувиар өсч 23.5 тэрбум төгрөгт, бусдаас татсан хөрөнгө 8.6 тэрбум төгрөгт хүрсэн бол нийт актив 28,6 хувиар өсч 27.2 тэрбум төгрөгт хүрлээ.

Бидэнд өндөр итгэл хүлээлгэн хамтран ажиллаж, бидний амжилтыг бүтээлцэж ирсэн, бүтээлцэж яваа харилцагч, түншүүд болон нийт ажилтнууддаа баярлаж талархаж явдгаа илэрхийлэхийн ялдамд, угтан тосож буй амжилт бүтээлийн он жилүүдийг хамтдаа туулахын ерөөл өргөө.

ГРУПП КОМПАНИ

Очир Ундраа Групп нь 2000 онд анх үүсгэн байгуулагдсан бөгөөд бидний бизнесийн ололт, амжилтуудын гол үндэс болсон нийт 900 гаруй ажилтнуудынхаа хамтын итгэл, сэтгэл, зүтгэл дээр түшиглэн өдгөө 12 салбар компанийн бүрэлдэхүүнтэйгээр өргөжин тэлж, хөгжин дэвшээд байна.

ОЧИРУНДРАА

Таны амжилтын ундраа



Тогтвортой
хөгжлийн
төлөө

IntelliCom
ТАНЫ БҮТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ



ОЧУН

ОЧИРУНДРАА
Таны амжилтын ундраа



ОЧИРУНДРАА
Амжилтын санхүүжүүлэг



ПРАКТИКАЛ
ДАДГАЛ



ӨСӨНТ
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ

▼ КОМПАНИЙН ТУХАЙ

Очир Ундраа ОМЗ ББСБ нь 2008 онд үүсгэн байгуулагдсан үндэсний хөрөнгө оруулалттай компани юм.


Манай байгууллага нь өдгөө 16000 гаруй харилцагчид 170 гаруй тэрбум төгрөгийн зээл олгож, уг санхүүжилтээр дамжуулан 3500 орчим ажлын байр бий болгон, 2018 оны байдлаар нийт хөрөнгө 27.2 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 18.4 тэрбум төгрөг, улсын төсөвт 2.1 тэрбум гаруй төгрөгийн татвар төлж санхүүгийн салбарын хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Бид алхам алхмаар хөгжин дэвшихийг эрмэлзэн дэвшилтэт технологи, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлж шуурхай зээл, хэрэглээний зээл, бизнесийн зээл, валют арилжаа, итгэлцлийн үйлчилгээг харилцагчиддаа мэргэжлийн өндөр төвшинд үзүүлж, үйлчилгээнээс хүртэх сэтгэл ханамжийг хамгийн өндөр түвшинд байлгахад зорьж байна.

Эрхэм таны үйл ажиллагааны онцлог, хэрэгцээнд нийцсэн санхүүгийн цогц бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгон хамтран ажиллахдаа бид үргэлж таатай байх болно.



БИДНИЙ ОЛОЛТ АМЖИЛТ





Нийгэм, эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулж буй шилдэг аж ахуй нэгжийг өргөмжилдөг оны онцлох "Банк бус санхүүгийн салбарын шилдэг Энтерпренер" байгууллагаар 2 жил дараалан шалгарлаа.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

БИД нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд бодит хувь нэмрээ оруулан, хүрээлэн буй орчинд ээлтэй бизнесийн үйл ажиллагаа, Монголын ирээдүй болсон хүүхдийн боловсрол хөгжлийг дэмжин, ажиллагсдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэн сайн сайхан бүхнийг дэмжин ажиллахыг зорьдог.

Ажилчдынхаа санхүүгийн асуудалд дэмжлэг үзүүлэх:

Очир Ундраа Групп компанийн нийт ажилтнуудад бага хүүтэй зээлийг орон сууц, автомашин худалдан авах болон гэр бүлийн бусад хэрэгцээнд зориулан олгож байна.

Ажиллах орчин:

Ажилтнуудынхаа эрүүл, аюулгүй, тав тухтай ажиллах орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор жил бүр хөрөнгө оруулалт хийн ажилладаг. Өнгөрсөн онд 86,385,511.0 төгрөгийн хөрөнгө оруулалт хийн, ажиллах орчинг бүрэн сайжруулсан.

Зорилтот төсөл:

Өрх толгойлсон эмэгтэйчүүдэд зориулсан “Итгэлийн гар”, Үндэсний үйлдвэрлэгч нарт зориулсан “Монгол шошго” зэрэг барьцаагүй, 1% хүүтэй зорилтот зээлүүдээрээ дамжуулан 2017 оноос хойш олгон 100 гаруй баялаг бүтээгчдийг дэмжин ажиллаад байна.

Хандив:

Монголын үндэсний хараагүйчүүдийн холбоотой 12 дахь жилдээ хамтран ажиллаж, Дэлхийн цагаан таягтны өдрийг тохиолдуулан, Харааны бэрхшээлтэй 150 иргэнд хүнсний тусламж үзүүлсэн.

ISO 9001:2015 стандарт:

Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн салбартаа анхдагч байгууллага болсон.

Эрүүл мэндийн үзлэг:

Салбартаа тэргүүлэгч Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран жил бүр байгууллагынхаа нийт ажилтнуудыг урьдчилан сэргийлэх иж бүрэн үзлэг оношилгоонд үнэ төлбөргүй хамруулдаг уламжлалтай.

ТОГТ
ХЭРЭГЖ
АЖЛ

Марафон гүйлт:

"Итгэл, Найдвар, Боломж" бүх нийтийн марафон гүйлтэд, 2017 оноос хойш жил бүр тасралтгүй оролцон, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих сайн үйлсийн аянд өөрсдийн хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Гар зургийн уралдаан:

Нийт групп компанийн ажилтнуудынхаа хүүхдүүдийн дунд, Олон улсын хүүхдийн баярыг угтан "Гар зургийн" уралдааныг 2016 оноос хойш зохион байгуулан, хүүхдүүдийн ур чадварыг хөгжүүлэн, шагнаан урамшуулж байна.

1000 цүнх аян:

Амьжиргааны баталгаажих төвшнөөс доогуур орлоготой эмзэг бүлгийн 1000 өрхийн хүүхдэд хичээлийн хэрэглэл бэлэглэх 1000 цүнх аянд 2016 оноос хойш жил бүр оролцон иж бүрэн хичээлийн хэрэгслийг 300 гаруй хүүхдэд хандивласан байна.

Соёлын ажил:

Жил бүр хамт олныхоо дунд зуны зугаалга зохион байгуулан, Монгол орныхоо түүхэн дурсгалт газруудаар аялж, танин мэдэхүйгээ хөгжүүлдэг уламжлалтай.

Спорт заал:

Ажилтнуудынхаа эрүүл чийрэг, хөдөлгөөнтэй байхад анхаарч долоо хоног бүр Тэмүжин Спорт зааланд үнэ төлбөргүй тоглох нөхцөл боломжоор хангадаг ба жил бүр группийн ажилтнуудын дунд спортын наадам зохион байгуулагддаг.

Сургалт хөгжил:

Ажилтнуудын оролцоо, бүтээмж, хөгжлийг дэмжих зорилгоор жил бүр дотоод болон гадаад сургалтын төлөвлөгөө гарган, ажилтнуудыг үнэ төлбөргүй хамруулан ажиллаж байна.



Хамтын ажиллагаа:

Жил бүр Монголын үндэсний уламжлалт цагаан сарын баярын угтан ахмад харилцагчиддаа хүндэтгэл үзүүлэн хүлээн авч, гарын бэлэг гардуулдаг уламжлалтай.

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

Бид харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг, техник технологийн дэвшилд тулгуурлан хурдан, шуурхай хүртээмжтэй хүргэхээр зорин ажиллаж байна.



Зээлийн
үйлчилгээ



Итгэлцлийн
үйлчилгээ



Валют
арилжаа



Санхүүгийн
зөвлөгөө



Цахим
үйлчилгээ



Мобайл
үйлчилгээ



Даатгалын
зуучлал

ЗОРИЛТОТ ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



Монгол шошго бичил бизнесийн зээл:

Жижиг дунд, өрхийн үйлдвэрлэгч нарт цогц системтэй, хүртээмжтэй санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар нэмүү үнэ цэнэ, баялаг бүтээгчийг бий болгоход оршино.



Итгэлийн гар төслийн зээл:

Жижиг дунд бизнес эрхлэгч, өрх толгойлсон эмэгтэйчүүдэд цогц системтэй, хүртээмжтэй санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар тогтвортой бизнесийн үйл ажиллагаа, өрхийн амьжиргааны төвшинг нэмэгдүүлэхэд оршино.



Эрдмийн Ундраа сургалтын зээл:

Тасралтгүй суралцах, өсөж хөгжих зорилго бүхий иргэдийн санхүүгийн асуудлыг шийдвэрлэх замаар Оюуны хөрөнгө оруулалтыг дэмжихэд оршино.



Хялбар зээл:

Тогтмол орлоготой иргэдийн богино хугацааны санхүү, мөнгөний асуудлыг хурдан шуурхай шийдвэрлэхэд оршино.

БАРЬЦААТ ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



Шуурхай
зээл



Бизнесийн
зээл



Хэрэглээний
зээл



Автомашин
лизингийн зээл



Боловсролын
зээл



Цалингийн
зээл



Итгэлцэл
барьцаалсан зээл



Шугаман
зээл

САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Нийт харилцагчийн тоо


17,000



Нийт актив

26,976.2

Нийт актив
(сая.төг)



■ 15,656.02
■ 18,911.9
■ 26,976.2

Төлсөн татварын хэмжээ
(Сая.төг)



■ 2,821.4
■ 3,232.6
■ 3,665.3

Өөрийн хөрөнгө
(сая.төг)



■ 12,012.8
■ 15,180.5
■ 17,983.2

Ашигт ажиллагаа
(сая.төг)



■ 2,538.18
■ 2,975.8
■ 3,064.9

Олгосон зээл (цэврээр)
(сая.төг)



■ 13,253.13
■ 16,733.5
■ 23,224.9

Татан төвлөрүүлсэн
хөрөнгө (сая.төг)



■ 2,500.4
■ 2,965.2
■ 4,297.3

■ 2016 ■ 2017 ■ 2018


ББС САЛБАРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018 оны 03-р улирлыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ББСБ-ын тоо 5 компаниар буюу 0.9 хувиар, хувьцаа эзэмшигчдийн тоо 1.3 хувиар, салбарт ажиллагсдын тоо 363 хүнээр нэмэгдэж 2652-д хүрсэн байна.

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 2018 оны III улирлын байдлаар 540 ББСБ 9 төрлийн 778 тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна. ББСБ-уудын 90.9% буюу 491 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 65.9% буюу 356 ББСБ дагнан эрхэлж байгаа бол 28.3% буюу 153 ББСБ гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 8.5% буюу 46 ББСБ дагнан эрхэлж байна.


2018 оны III улирлын байдлаар давхардсан тоогоор 4766 хувь нийлүүлэгчдийн 540 ББСБ, 206 салбар нэгж, 5 төлөөлөгчийн газар, 2652 ажилтантайгаар Монгол улсын 21 аймагт 1,510,982 харилцагчдад хүрч үйлчилж байна. Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар өсч 1,5 саяд хүрлээ. Тэдгээрийн 48.6% нь эмэгтэй, 51.2% нь эрэгтэй, 0.2% нь хуулийн этгээд байна. 83.1 хувийг 2 ББСБ-ын харилцагчид бүрдүүлж байна.

№	Утга	2017-3	2018-3	Өөрчлөлт
1	Ажиллагсадын тоо	2289	2652	15.9%
2	ББСБ тоо	535	540	0.9%
3	Нийт актив (тэрбум.төг)	906.0	1,202.0	32.7%
4	Нийт зээл (тэрбум.төг)	592.4	811.6	37.0%
5	Өөрийн хөрөнгө (тэрбум.төг)	716.8	932.0	30.0%
6	Цэвэр ашиг (тэмбум.төг)	43.7	73.5	68.3%



Бид ISO 9001:2015 олон улсын стандартыг бизнесийн болон хэрэглээний зээлийн үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн салбартаа анхдагч байгууллага болж, БНЭУ-ын "IRCLASS systems and solutions private limited" олон улсын баталгаажуулалтын байгууллагаас батламжаа гардан авлаа.

АМЖИЛТЫГ САНХҮҮЖҮҮЛНЭ



ХҮНИЙ НӨӨЦ

Ажилтан бүрт мэдрэмж, шинэчлэлийг хослуулан ахиж дэвжих, тасралтгүй хөгжиж, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх боломж олгох асуудал бидний эрхэмлэх чухал зүйлийн тэргүүн эгнээнд байдаг. Шударга үнэнийг эрхэмлэн хариуцлагатай, бүтээлч, бусдад хүндэтгэлтэй, ойлгомжтой, нээлттэй, тодорхой байх нь бидний алхам тутам, ажил үйлсдээ хэрэгжүүлж явах үнэт зүйлсэд багтдаг.

Бид манлайлдаг

Сүүлийн 13 жил Монгол Улсын Засгийн Газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас олгодог “Үндэсний Шилдэг аж ахуйн нэгж” өргөмжлөлийг тасралтгүй хүртсэн шилдэг, нэр хүндтэй, үндэсний байгууллагын нэг.

Бид хөгжүүлдэг

Мэргэжлээрээ болон өөрийгөө хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөрт хамрагдаж, мэдлэг, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжтой.

Бид боломж олгодог

Албан тушаал ахиж дэвших орчныг бүрдүүлсэн ижил тэгш боломж.

Бид оролцоог эрхэмлэдэг

Дотоод менежментийн асуудлуудаа нийт ажилтнуудаа оролцуулан тэдний саналд тулгуурлан шийдвэрлэдэг.

Бид хөрвөх чадвартай

Бид бизнесийн олон чиглэлд хөрвөн ажиллах боломжийг олгодог.

Бид дэмждэг

Шинэ оновчтой санаа, санаачлагыг урамшуулан дэмждэг системтэй.

Бид урамшуулдаг

Зах зээлд өрсөлдөхүйц тогтмол цалин олгож ажлын үр дүн, гүйцэтгэл, ур чадварт тулгуурлан нэмж олгодог шагнал урамшууллын системтэй.

Бид ёс зүйг эрхэмлэдэг

Зөв, шударгыг эрхэмлэн дээдэлдэг үнэт зүйлс соёлтой, “Ёс зүйн дүрэм” боловсруулан хэрэгжүүлдэг.

Бид бусдыг сонсдог

Менежментээ сайжруулах боломж нь хэрэглэгчдээс ирсэн санал, гомдол бөгөөд бид энэхүү асуудлыг хүлээн авч бүрэн шийдвэрлэдэг.

ХАМТРАН АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГУУД





АУДИТЫН ТАЙЛАН

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Энэхүү тайланд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь "Очир Ундраа ОМЗ ББСБ" Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн 2018 оны 12-р дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх үүднээс хийгдсэн болно.

"Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК-ийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй болно. Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС"), Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

	Тодруулга	2018.12.31 мян.төг	2017.12.31 мян.төг
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгөн хөрөнгө	6.1.	799,848.3	1,204,198.2
Зээл /цэвэр/	6.2.	23,224,896.6	16,733,513.8
Хуримтлуулж тооцсон хүүний авлага	6.2.	456,184.8	342,584.8
Бусад авлага	6.6.	8,931.0	7,032.8
Бусад хөрөнгө	6.6.	44,167.8	64,972.4
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		24,534,028.5	18,352,301.9
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө (цэвэр)	6.7.	1,688,948.4	73,872.9
Биет бус хөрөнгө (цэвэр)	6.8.	69,225.0	2,600.0
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	6.9.	684,000.0	684,000.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		2,442,173.4	760,472.9
НИЙТ ХӨРӨНГӨ		26,976,201.8	19,112,774.9
ЭХ ҮҮСВЭР			
ӨР ТӨЛБӨР			
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	6.3.	3,811,325.0	627,275.0
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	6.4.	4,297,264.5	2,965,158.6
Хуримтлуулж тооцсон хүүний өглөг	6.5.	184,550.0	176,233.6
Бусад өглөг	6.10.	699,843.9	163,630.7
ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		8,992,983.4	3,932,297.9
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
Энгийн хувьцаа	6.11.	2,500,000.0	2,500,000.0
Нэмж төлөгдсөн капитал	6.11.	684,000.0	684,000.0
Нөөцийн сан	6.11.		247,672.5
Нийгмийн хөгжлийн сан	6.11.	28,054.3	35,438.1
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	6.11.	14,771,164.2	11,713,366.4
Өөрийн хөрөнгийн дүн		17,983,218.5	15,180,476.9
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		26,976,201.8	19,112,774.9





Төв оффис: СБД, 1-р хороо, Сөүлийн 6А гудамж, Сөүл плаза, 401 тоот | Утас: 75751818
Салбар-1: СХД, 10-р хороо, УБ Виста төв, 103 тоот. | Утас: 77331818
Салбар-2: БЗД, 1-р хороо, Альфа бюлдинг, 201 тоот | Утас: 70169696
Салбар-3: Орхон аймаг, Эрдэнэт хот, Баян-Өндөр сум, Саруул оффис, 102 тоот | Утас: 70351818

Лавлах утас: 75751818
Вэб сайт: www.omz.mn
И-мэйл: info@omz.mn
Facebook: Ochir Undraa OMZ
Twitter: OU_OMZ